



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/04

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хоол, хүнсний материал нийлүүлэх” тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Нямдорж - Ерөнхий боловсролын сургуулийн  
багш

Нарийн бичгийн дарга: Д.Чанцал - 2 дугаар Цэцэрлэгийн нярав

Гишүүд: С.Гэрэлт-Од - Ерөнхий боловсролын сургуулийн  
багш

Б.Эрдэнэчимэг - Ерөнхий боловсролын сургуулийн  
багш

Т.Даваадорж - Иргэний төлөөлөл (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Э.Нямдорж)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж байгууллагын Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Чанцал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ